



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

Г“Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д
нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 12^{1.9} дэх заалт, Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 327 дугаар тогтоолоор зөвшөөрч, тус Холбооны Удирдах зөвлөлөөр батлагдсан “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.9.3¹ дэх заалт нэмэхийг зөвшөөрсүгэй:

1/ ”6.9.3¹. Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн Холбооны гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;” гэж.

2. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Холбооны гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо томилж, чөлөөлнө.” гэснийг хасахыг зөвшөөрсүгэй.

3. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-дээ Хорооноос зөвшөөрсөн нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэлбэржүүлэн ирүүлэхийг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл /Г.Хэрлэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН